

**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА (2021 ОНЫ УРЬДЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛ)



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт **16,095.8** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс

25.0 хувь буюу **3,220.5** сая ам.доллараар өсөж, гадаад худалдааны тэнцэл **2,641.9** сая ам.долларын ашигтай гарсан байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	12 сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт (өмнөх оны мөн үеэс)	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	12,886.6	13,747.1	12,875.2	16,095.8	3,220.5	25.0
-Экспорт	7,011.8	7,619.6	7,576.3	9,247.1	1,670.8	22.1
-Импорт	5,874.8	6,127.5	5,298.9	6,848.6	1,549.7	29.2
Тэнцэл	1,137.0	1,492.1	2,277.4	2,398.5	121.1	5.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл 2,398.5 сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 121.1 сая ам.доллар буюу 5.3 хувиар өсөхөд импорт 1,549.7 сая ам.доллар, экспорт 1,670.8 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Экспорт: Экспортын худалдаа 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9,247.1 сая ам.долларт хүрч, эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үетэй харьцуулахад 1,627.5 сая ам.доллар буюу 21.4 хувиар, харин 2020

оны мөн үетэй харьцуулахад 1,670.8 сая ам.доллар буюу 22.1 хувиар өссөн байна.

Импорт: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр импорт 6,848.6 сая ам.доллар болж 2019 оны мөн үетэй харьцуулахад 721.1 сая ам.доллар буюу 11.8 хувиар, 2020 оны мөн үеэс 1,549.7 сая ам.доллар буюу 29.2 хувиар тус тус өссөн байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын **81.3** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **18.7** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **7,516.0** сая ам.долларт хүрч, өмнөх оноос **2,259.9**

сая ам.доллар буюу 43.0 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **1,731.2** сая ам.доллар болж, өмнөх оноос **589.1** сая ам.доллар буюу **25.4** хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	12 сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	6,070.3	6,377.6	5,256.0	7,516.0	2,259.9	43.0	81.3
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	941.4	1,242.0	2,320.3	1,731.2	-589.1	-25.4	18.7
Нийт экспорт	7,011.8	7,619.6	7,576.3	9,247.1	1,670.8	22.1	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 31.4 хувийг зэсийн баяжмал, 29.9 хувийг нүүрс, 10.3 хувийг төмрийн хүдэр, 10.9 хувийг боловсруулаагүй

алт, 3.0 хувийг боловсруулаагүй нефть, 1.9 хувийг цайрын хүдэр, 1.6 хувийг жоншны хүдэр эзэлсэн байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	12 сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
		2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	1,436.7	1,403.6	1,395.1	1,282.5	-112.5	-8.07
Нүүрс	сая.тн	35.8	36.5	28.6	15.7	-12.9	-45.1
Төмрийн хүдэр, баяжмал	сая.тн	7.4	8.4	8.2	7.1	-1.1	-13.4
Цайрын хүдэр, баяжмал	мян.тн	123.9	134.8	134.1	112.6	-21.4	-16.0
Алт	тн	3.4	9.1	30.5	17.2	-13.2	-43.4
Боловсруулаагүй нефть	сая.баррель	6.2	6.5	4.1	4.3	0.3	6.8
Катодын зэс	тн	12.9	11.9	9.6	9.8	0.2	2.1
Жоншны баяжмал	мян.тн	555.2	700.1	678.9	644.7	-34.2	-5.0
Адууны мах	мян.тн	32.2	30.8	17.6	7.0	-10.5	-60.0
Өлөн гэдэс	тн	445.8	419.5	503.1	642.9	139.9	27.8

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	79.5	68.6	23.4	7.6	-15.8	-67.6
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	0.3	592.8	344.0	441.4	97.4	28.3
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	116.2	54.0	49.2	66.3	17.1	34.7
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	145.5	121.0	85.2	77.0	-8.2	-9.6
Самнасан ноолуур	тн	630.2	507.2	260.0	424.0	164.0	63.1
Бохир ноолуур	тн	5,286.6	5,688.7	6,339.8	6,026.9	-313.0	-4.9
Хонины самнаагүй ноос	мян.тн	12.2	14.8	8.5	5.4	-3.0	-35.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	12 сар (өссөн дүнгээр)				Өмнөх оны мөн үеэс	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	2,012.2	1,795.9	1,778.0	2,899.9	1,121.9	63.1
Нүүрс	2,786.2	3,074.4	2,123.7	2,763.9	640.3	30.1
Төмрийн хүдэр	342.2	576.4	640.0	952.2	312.2	48.8
Цайрын баяжмал	197.8	189.0	167.7	176.4	8.7	5.2
Алт	144.5	418.4	1,787.7	1,004.5	-783.1	-43.8
Боловсруулаагүй нефть	392.0	3.8	150.9	273.4	122.5	81.2
Катодын зэс	82.4	68.9	59.3	88.5	29.2	49.3
Жоншны баяжмал	189.9	205.5	156.3	144.1	-12.2	-7.8
Адууны мах	65.0	57.7	33.0	14.4	-18.5	-55.9
Өлөн гэдэс	8.6	8.5	8.9	15.3	6.4	71.1
Үхэр, адууны боловсруулсан шир	8.4	6.4	2.3	0.8	-1.4	-62.8
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.01	1.8	0.5	0.7	0.2	50.1
Хонь, хурганы боловсруулсан арьс	3.1	1.2	1.0	1.3	0.3	31.8
Ямаа, ишигний боловсруулсан арьс	5.0	4.0	3.1	2.4	-0.7	-22.0
Самнасан ноолуур	54.9	45.3	16.9	39.9	23.0	136.6
Бохир ноолуур	252.0	283.3	185.3	253.6	68.3	36.9
Хонины самнаагүй ноос	20.2	20.4	9.0	5.4	-3.4	-37.6
Нийт экспортод эзлэх хувь	93.6%	88.7%	94.0%	93.4%		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс **2,259.9** сая ам.доллар буюу **43.0** хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

1. Нүүрс: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр **15.7** сая тонн нүүрс экспортолж, **2,763.9** сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ 12.9 сая тонноор буурсан боловч экспортын орлого 640.3 сая ам.доллараар буюу 30.1 хувиар өссөн байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 101.8 ам.доллар буюу 137.1 хувиар нэмэгдсэн нь нүүрсний экспортын орлого өсөхөд нөлөөлжээ.

2.Зэсийн баяжмал: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 63.1 хувь буюу 1,121.9 сая ам.доллараар нэмэгдэж, **2,899.9** сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ **1,282.5** мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 8.1 хувь буюу 112.5 мянган тонноор буурсан ба экспортын дундаж үнэ нь 77.4 хувиар өссөн байна.

3.Төмрийн хүдэр: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ **7.1** сая тонн болж, **952.2** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 48.8 хувь буюу 312.2 сая ам.доллараар өсөхөд төмрийн хүдрийн биет хэмжээ 13.4 хувь буюу 1.1 сая тонноор буурсан боловч 1 тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 71.8 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

4.Цайрын баяжмал: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ **112.6** мянган тонн болж, **176.4** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 5.2 хувь буюу 8.7 сая ам.доллараар өсөхөд цайрын баяжмалын биет хэмжээ 16.0 хувь буюу 21.4 мянган тонноор буурсан боловч 1 тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 25.3 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

5. Боловсруулаагүй нефть: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр боловсруулаагүй нефтийн экспортын тоо хэмжээ **4.3** сая баррельд хүрч, **273.4** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Боловсруулаагүй нефтийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 81.2 хувь буюу 122.5 сая ам.доллараар өсөхөд биет хэмжээ нь эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үеэс 2.2 сая баррель буюу 33.6 хувиар буурсан боловч өмнөх оны мөн үеэс 6.8 хувь буюу 0.3 сая баррелиар өссөн, мөн тайлант хугацаанд 1 тонн түүхий газрын тосны экспортын дундаж үнэ 72.8 хувиар нэмэгдсэн нь тус тус нөлөөлсөн байна.

6. Катодын зэс буюу тунгаасан зэс ба хайлш: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр катодын зэсийн экспортын тоо хэмжээ **9.8** тоннд хүрч, **88.5** сая ам.долларын экспортын орлого олсон байна. Катодын зэсийн экспортын орлого 2019 оны мөн үеэс 28.5 хувь буюу 19.6 сая ам.доллараар, өмнөх оны мөн үеэс 49.3 хувь буюу 29.2 сая ам.доллараар өссөн нь катодын зэсийн биет хэмжээ 2.1 хувь буюу 0.2 тонноор өссөн, 1 тонн тунгаасан зэсийн экспортын дундаж үнэ 46.2 хувиар нэмэгдсэн нь тус тус нөлөөлсөн байна.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Нийт импортын **19.5** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **80.5** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **1,338.6** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс **331.3** сая ам.доллараар буюу 32.9 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 5,510.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1,218.4 сая ам.доллар буюу 28.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Эрдсийн бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	12 сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	1,325.8	1,372.3	1,007.2	1,338.6	331.3	32.9	19.5
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	4,549.0	4,755.2	4,291.7	5,510.1	1,218.4	28.4	80.5
Нийт импорт	5,874.8	6,127.5	5,298.9	6,848.6	1,549.7	29.2	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн **19.5** хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг **18.2** хувь, автотээвэр, агаарын тээврийн хэрэгсэл тэдгээрийн эд анги **17.9** хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл **14.1** хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн **8.6** хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн **8.3** хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 6. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	Импорт		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2020.12	2021.12	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	77.7	121.3	43.6	56.1	1.8
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	120.2	187.6	67.5	56.1	2.7
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	35.8	46.5	10.7	29.9	0.7
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	434.4	607.2	172.9	39.8	8.9
5	Эрдэс бүтээгдэхүүн	1,007.2	1,338.6	331.3	32.9	19.5
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	370.8	587.4	216.6	58.4	8.6
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс, хаймар болон түүгээр хийсэн зүйлс	223.1	252.1	29.0	13.0	3.7
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	5.0	6.4	1.4	28.2	0.1
9	Мод, модон эдлэл	43.4	67.3	23.9	55.1	1.0
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	58.1	64.3	6.3	10.8	0.9
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	85.8	103.8	18.0	20.9	1.5
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	17.9	24.6	6.7	37.4	0.4
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	165.8	159.2	-6.7	-4.0	2.3
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	13.4	7.2	-6.2	-46.4	0.1
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	535.7	567.2	31.5	5.9	8.3
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	1,060.6	1,248.7	188.1	17.7	18.2
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	849.8	1,228.4	378.6	44.5	17.9
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг тэдгээрийн эд анги	103.8	127.2	23.3	22.5	1.9
19	Зэвсэг, галт хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон тоног хэрэгсэл	11.0	3.2	-7.8	0.0	0.0
20	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	79.3	100.4	21.1	26.5	1.5
21	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.05	0.2	0.1	222.6	0.002
	ДҮН	5,298.9	6,848.6	1,549.7	29.2	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага 2021 он онд 3,560.2 тэгрөгийн орлого төвлөрүүлж, 98.5 хувийн тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх гүйцэтгэлтэй байна. төлөвлөгөөтэйгээс 3,508.2 тэрбум

Хүснэгт 7. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2020.12	2021.12		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь
Нийт орлого	2,891.9	3,560.2	3,508.2	616.3	121.3	-52.0	98.5
Гаалийн албан татвар	740.7	935.0	943.1	202.4	127.3	8.1	100.9
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,503.8	1,914.0	1,902.3	398.5	126.5	-11.7	99.4
Архи, дарсны онцгой албан татвар	11.2	14.0	20.4	9.2	182.1	6.4	145.7
Тамхины онцгой албан татвар	123.4	138.0	130.8	7.4	106.0	-7.2	94.8
Шар айрагны онцгой албан татвар	2.1	2.2	5.8	3.7	276.2	3.6	263.6
Суудлын автомашины онцгой албан татвар	172.3	200.0	202.6	30.3	117.6	2.6	101.3
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	252.8	260.0	240.4	-12.4	95.1	-19.6	92.5
Автобензин, дизель түлшний албан татвар	17.1	15.0	16.7	-0.4	97.7	1.7	111.3
Экспортын татвар	0.012	0.03	0.04	0.028	0.0	0.01	0.0
Татварын дүн	2,823.4	3,478.2	3,462.1	638.7	122.6	-16.1	99.5
Өөрийн орлого	5.6	22.0	6.2	0.6	110.7	-15.8	28.2
Хураамж	62.9	60.0	39.9	-23.0	63.4	-20.1	66.5

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого **616.3** тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Гаалийн албан татвар **202.4** тэрбум төгрөг;
- Нэмэгдсэн өртөгийн албан татвар **398.5** тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар **9.2** тэрбум төгрөг;
- Тамхины онцгой албан татвар **7.4** тэрбум төгрөг;
- Шар айрагны онцгой албан татвар **3.7** тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар **30.3** тэрбум төгрөг;
- Экспортын гаалийн албан татвар **28.0** сая төгрөгөөр тус тус өссөн.

Харин автобензин, дизель түлшний онцгой албан татвар 12.4 тэрбум төгрөг, автобензин, дизель түлшний албан татвар 0.4 тэрбум төгрөг, хураамжийн орлого 23.0 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Зарим төрлийн импортын бараанд ногдуулсан онцгой албан татварын орлого бүрдэлт, импортын тоо хэмжээний талаар:

Онцгой албан татвартай барааны импортыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 19.3 хувиар буюу 275.0 тэрбум төгрөгөөр, ногдуулсан татвар 17.0 хувиар буюу 85.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Онцгой албан татвартай суудлын автомашин: Тайлант хугацаанд онцгой албан татвартай суудлын автомашин 55,317 ширхгийг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1,966 ширхэг буюу 3.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 3,286 ширхгээр өссөн бол, бусад суудлын автомашин 1,320 ширхгээр буурчээ.

Хүснэгт 8. Онцгой албан татвартай суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Импортын тоо хэмжээ				Ногдуулсан татвар			
	2020.12	2021.12	Зөрүү	Хувь	2020.12	2021.12	Зөрүү	Хувь
Төрөл								
Хос тэжээлт	38,162	41,448	3,286	108.6	104.0	129.7	25.7	124.7
Бусад	15,189	13,869	-1,320	91.3	68.1	72.7	4.7	106.8
Нийт	53,351	55,317	1,966	103.7	172.1	202.4	30.3	117.6

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Автобензин, дизелийн түлш: Монгол улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2020 онд 1,612.8 мянган тонн, 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр **1,565.9** мянган тонн автобензин, дизелийн түлшний бүтээгдэхүүн импортолсон байна.

2021 оны 07 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан “Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн дагуу газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосинд тонн тутамд 285.0 мянган төгрөгийн онцгой албан татварыг 2021 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ногдуулж эхэлснээр нийт **46.1** мянган тонн бүтээгдэхүүн импортоор орж ирсэнд **4.5** тэрбум төгрөгийн онцгой албан татвар ногдуулж улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 9. Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Төрөл	Импортын тоо хэмжээ /мян.тонн/				Ногдуулсан татвар			
	2020.12	2021.12	Зөрүү	Хувь	2020.12	2021.12	Зөрүү	Хувь
Нийт	1,612.7	1,565.8	-46.9	97.1	242.3	231.2	-11.1	95.4
Автобензин	A-80	57.4	58.9	1.5	102.6	0.0	0.0	0.0
	A-92	496.7	489.4	-7.3	98.5	0.0	0.0	0.0
	A-95 болон түүнээс дээш	31.1	29.0	-2.1	93.2	6.4	6.1	-0.3
Дизель түлш	1,027.5	988.5	-39.0	96.2	235.9	225.1	-10.8	95.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хураамжийн орлого: Улсын төсөвт хураамжийн орлогоор 60.0 тэрбум төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 39.9 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 66.6 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хураамжийн орлого 23.0 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Экспортоор гаргасан эрдэс бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн хураамж нь нийт хураамжийн 92.0 хувийг эзэлж байна.

Хүснэгт 10. Гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын хураамжийн орлого /мянган тонн, сая төгрөг/

Экспортын эрдэс бүтээгдэхүүний гол нэрийн бараа	2020.12		2021.12		Өөрчлөлт 2021/2020	
	Тоо хэмжээ	Хураамж	Тоо хэмжээ	Хураамж	Тоо хэмжээ	Хураамж
Жонш	678.9	1,018.4	644.3	966.4	-34.6	-52.0
Төмрийн хүдрийн баяжмал	8,205.7	12,308.6	7,106.2	10,659.3	-1,099.5	-1,649.3
Зэсийн баяжмал	1,340.7	2,011.0	1,282.5	1,923.8	-58.1	-87.2
Цайрын баяжмал	123.4	185.2	112.6	168.9	-10.8	-16.3
Чулуун нүүрс	28,586.9	42,880.3	15,700.6	23,550.9	-12,886.3	-19,329.5
Хүрэн нүүрс	90.0	135.0	32.3	48.4	-57.7	-86.6
Түүхий нефть/мянган баррель/	4,070.5	6.1	4,348.9	6.5	278.4	0.4
Бусад		122.0		655.3	-	533.4
Нийт		58,666.5		37,979.5		-20,686.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тав. Татварын чөлөөлөлт

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээр **2,023.8** тэрбум төгрөг буюу нийт импортын 10.4 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт **3,899.0** тэрбум төгрөгөөр буюу 1.3 дахин, татвараас чөлөөлөгдсөн

импорт **672.0** тэрбум төгрөгөөр буюу 1.6 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **1.3** нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2020.12	2021.12	Өөрчлөлт (+,-)	Хувиар
Татвартай импорт	12,581.1	15,807.2	3,226.0	125.6%
<i>Эзлэх хувь</i>	<i>91.4%</i>	<i>89.7%</i>	<i>-1.7%</i>	
Татвараас чөлөөлөгдсөн импорт	1,180.6	1,816.7	636.1	153.9%
<i>Эзлэх хувь</i>	<i>8.6%</i>	<i>10.3%</i>	<i>1.7%</i>	
Нийт импорт	13,761.7	17,623.9	3,862.2	128.1%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 2,032.8 тэрбум төгрөгийн импортын бараанд ногдох 337.1 тэрбум төгрөгийн татвар хуулийн дагуу чөлөөлөгдсөн байна. Чөлөөлөгдсөн татварын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **99.3** тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Улаанбуудайн үр, хүнсний улаанбуудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тос зэрэг 320.7 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **48.9** тэрбум төгрөгийн татвар;
2. Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан зээлийн хүрээнд 278.8 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **45.0** тэрбум төгрөгийн татвар;
3. “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн БНМАУ-ЗСБНХУ-ын хооронд байгуулсан 1949 оны хэлэлцээр, мөн УИХ-ын 2016.09.07-ны өдрийн “Онцгой албан татвараас чөлөөлөгдөх тухай хууль”-ийн хүрээнд 349.5 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **83.1** тэрбум төгрөгийн татвар;
4. Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламжийн хүрээнд 117.6 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **18.0** тэрбум төгрөгийн татвар;
5. Иргэний агаарын тээврийн зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг 95.0 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **14.8** тэрбум төгрөгийн татвар;
6. Бусад төрлийн барааны хувьд татварын холбогдох хуулийн зүйл, заалтуудаар 663.7 тэрбум төгрөгийн статистик дүн бүхий бараанд ногдуулсан **101.3** тэрбум төгрөгийн татварыг тус тус чөлөөлсөн байна.

Д/д	Үзүүлэлт	2020.12		2021.12		Өөрчлөлт (2021/2020)	
		үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар	үнийн дүн	чөлөөлсөн татвар
1	Улаанбуудайн үр, хүнсний улаанбуудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тос	198.6	30.8	320.7	48.9	122.1	18.1
2	Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ	390.1	93.7	349.5	83.1	-40.6	-10.5
3	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	142.7	21.1	117.6	18.0	-25.1	-3.1
4	Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	53.7	9.4	95.0	14.8	41.3	5.4
5	Засгийн газрын болон Олон улсын байгууллагын зээл	206.8	31.2	278.8	45.0	72.0	13.8
6	Хийн түлш, тэдгээрийн тоног төхөөрөмж	68.4	10.7	88.3	13.7	19.8	3.0
7	Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	7.1	1.0	29.1	3.8	22.0	2.7
8	ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	52.1	5.2	81.2	8.5	29.1	3.3
9	Бусад	232.3	34.7	663.7	101.3	431.4	66.6
	Дүн	1,351.8	237.8	2,023.8	337.1	672.0	99.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Зургаа. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлтэд нөлөөлсөн хүчин зүйлс

2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр эдийн засгийн нөхцөл байдал эргэн сэргэж гадаад худалдааны бараа эргэлт өмнөх оны мөн үеэс 28.6 хувиар илүү байгаа боловч манай улс дотооддоо бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж 4 удаа хөл хорио тогтоосон, түүнчлэн 4 дүгээр улиралд БНХАУ-ын Эрээн хотын боомт тодорхойгүй хугацаагаар хилээ хаасан зэрэг шалтгаануудын улмаас гаалийн татварын орлогын төлөвлөгөө 98.5 хувийн биелэлттэй буюу 52.0 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна. Татварын орлогын төлөвлөгөө тасрахад гол нөлөө үзүүлсэн орлогын төрлөөр авч үзвэл;

Хураамжийн орлого 20.0 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн. Цар тахлын халдвар дотоодод нэмэгдсэнтэй холбогдуулан БНХАУ-ын талаас нүүрсний экспортын гол боомтуудаар нэвтрэх машины тоог бууруулах болсны улмаас нүүрсний экспорт оны эцэст төлөвлөсөн хэмжээндээ хүрээгүй буюу 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр 15.7 сая тонн нүүрс экспортолжээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 82.0 хувиар буурсан үзүүлэлт юм.

Өөрийн орлого 15.9 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн. Засгийн газраас 2019 оноос эхлүүлэн хэрэгжүүлж буй хилийн боомтууд дахь эрдэс бүтээгдэхүүн, газрын тос, автобензин, дизель түлшний төрөлжсөн, орчин үеийн лабораториудыг үе шаттайгаар байгуулан, лабораторийн техник тоног төхөөрөмж, хүчин чадлыг шинэчлэх “Гаалийн шинэчлэл” ажлын хүрээнд энэ төрлийн орлого өснө гэж тооцооноор гаалийн байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлж төлөвлөсөн нь биелээгүй байна.

Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 19.5 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр нүүрсний экспортын биет хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй нь дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр хөрш БНХАУ болон манай улс

дотооддоо хөл хорио тогтоосонтой холбоотой юм. Үүнтэй холбогдуулан нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүдийн дизелийн түлшний хэрэглээ төлөвлөснөөс буурсан учраас өнгөрсөн оны мөн үеэс 3 хувиар буурсан. Энэ нь дизель түлшний онцгой албан татвар, дизель түлшний албан татварын орлого төлөвлөснөөс 19.5 тэрбум төгрөгөөр тасрахад голлон нөлөөлсөн гэж үзэж байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС